



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 02 сарын 22 өдөр

Дугаар А/117

Арвайхээр сум

Хивэг хуваарилах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3, 32.1.6 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн “Хөрөнгө гаргах тухай” 63 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Өвөлжилт нэн хүндэрсэн сумдад хуваарилсан нөөцийн барааны түгээлтэд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг 1 дүгээр, Онцгой байдлын газрын Улсын нөөцийн салбар цэгүүдээс үнэгүй олгох тэжээлийн хуваарийг 2 дугаар, сумдад хүргэх тэжээлийн тээврийн зардлын тооцоог 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан 32,360,000 (гучин хоёр сая гурван зуун жаран мянга) төгрөгийг аймгийн гамшгаас хамгаалах эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

3.Хивэг тээвэрлэсэн автомашины жолооч нартай гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир)-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газар дарга (дэд хурандаа Д.Одонбаяр)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН

6224 11 0243

Аймгийн Засаг даргын 2024 оны ⁰⁸ дугаар сарын ²² -ны өдрийн ^{47/117} дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



**ТУС АЙМГИЙН УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАР ЦЭГҮҮДЭЭС ОЛГОХ
ТЭЖЭЭЛД ХЯНАЛТ ТАВИХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч: Д.Одонбаяр (Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Онцгой байдлын газрын дарга, дэд хурандаа)


Гишүүд:

С.Цэдэнбалжир (Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хөдөө аж ахуйн газрын дарга)

Б.Ундармаа (Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, Онцгой байдлын Улсын нөөцийн салбарын дарга, хошууч)

Д.Лхагважав (Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газрын . Хяналтын албаны дарга)


Аймгийн Засаг даргын 2024 оны *04* дугаар
сарын *04* -ны өдрийн *011/24* дугаар
захирамжийн 2 дугаар хавсралт



УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАР ЦЭГЭЭС СУМДАД
ҮНЭГҮЙ ОЛГОХ ХИВЭГНИЙ ХУВААРЬ

№	Улсын нөөцийн салбар цэгийн нэр	Сумын нэр	Хивэг (тн)	Хивэг (шуудайгаар) 25кг
1	Хархорин	Хархорин	50	2,000
		Хужирт	50	2,000
2	Арвайхээр	Богд	60	2,400
		Бат-Өлзий	30	1,200
		Төгрөг	30	1,200
		Зүүнбаян-Улаан	20	800
		Аймгийн онцгой комисс	10	400
3	Нарийнтээл	Баруунбаян-Улаан	60	2,400
		Гучин-Ус	40	1,600
4	Сант	Өлзийт	30	1,200
		Есөнзүйл	30	1,200
		Бүрд	40	1,600
		Бүгд	450	18,000

Аймгийн Засаг даргын 2024 оны 02 дугаар
сарын 22 -ны өдрийн 4117 дугаар
захирамжийн 3 дугаар хавсралт



УЛСЫН НӨӨЦИЙН САЛБАР ЦЭГЭЭС СУМДАД
ҮНЭГҮЙ ОЛГОХ ХИВЭГНИЙ ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

№	Улсын нөөцийн салбар цэгийн нэр	Сумын нэр	Хивэг (тн)	Хивэг (25) кг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	Хархорин	Хархорин	50	2000		
		Хужирт	50	2000	1000	2,000,000
2	Арвайхээр	Богд	60	2400	2500	6,000,000
		Төгрөг	30	1200	1000	1,200,000
		Зүүнбаян-Улаан	20	800	500	400,000
		Бат-Өлзий	30	1200	1500	1,800,000
		Аймгийн онцгой комисс	10	400		
3	Нарийнтээл	Баруунбаян-Улаан	60	2400	2500	6,000,000
		Гучин-Ус	40	1600	2000	3,200,000
4	Сант	Өлзийт	30	1200	2300	2,760,000
		Есөнзүйл	30	1200	2500	3,000,000
		Бүрд	40	1600	3750	6,000,000
		Нийт	450			32,360,000